



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 27-өдөр

Дугаар А/М

Сант сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, 4.1, сумын Засаг даргын зөвлөлийн 2023 оны 01 сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хушаат багийн худагийн мотор хөлдөхөөс сэргийлж цахилгаан халаагуур авах шаардлагатай байгаа тул халаагуурын зардалд 190,000.0 (нэг зуун ерөн мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган зарцуулахыг төсвийн нягтлан бодогч (Ч.Мөнхзаяа)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Г.Ууганцэцэг)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: Ч. Монгоя,
Хянасан: Ч. Азиев,
Хувь: 2,
Огноо: 2025 01 27.